

**УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ
ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

*Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын
4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг
хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог
хийх аргачлал”-ын дагуу боловсруулав.*

2026 он

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Нэг. Ерөнхий зүйл

Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 83 дахь зүйлийн 1.9-т “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулахаар тусгасан.

Энэ тогтоолд “уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагаанд баримтлах зарчим, оролцогч төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгох, нэр томьёо, хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох, үнэлэх, хяналт шинжилгээ хийх, тайлагнах, тоо бүртгэл гаргахтай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг бий болгох, уур амьсгалын өөрчлөлтийн хэмжилт, судалгаа, үр дагаврын үнэлгээ болон мэдээллийн сантай холбоотой асуудлууд уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилтийг улс, орон нутгийн төсөвт тусгаж санхүүжүүлэх, нүүрстөрөгчийн кредитийг тооцох, сайн дурын болон албан ёсны зах зээлийн зохицуулалт, нүүрстөрөгчийн чөлөөт зах зээл дэх арилжааны механизмтай холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох”-оор тусгагдсан билээ.

Дээрх зорилтын хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд уг хуулийн зорилго нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн, хүлэмжийн хийн тэг ялгаралд хүргэхэд чиглэсэн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн механизм, карбон зах зээлийг хөгжүүлэх, хүлэмжийн хийн тооллого, бүртгэл, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд оршино гэж тодорхойлсон байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын дагуу тооцлоо.

Зардлын тооцоо хийх хуулийн төсөл нь анхдагч хуулийн хэлбэрээр боловсруулагдсан бөгөөд төслөөр хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад шинээр болон өмнө гүйцэтгэж байсан үүрэгт шинээр нэмэгдэх, эсхүл хасагдах чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд хийгдэнэ.

Хуулийн төсөл нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох болон даван туулах, хүлэмжийн хийн тэнцлийг хангахад чиглэсэн байгаль орчин, эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангах, карбон зах зээлийг бүрдүүлэх, уур амьсгалын санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлттэй

холбоотой бүртгэл, мэдээллийн сан, тайлагналын нэгдсэн тогтолцоог бий болгоход чиглэсэн харилцааг зохицуулсан байна.

Аргачлалд заасны дагуу хуулийн төслийн зохицуулалтаар шинээр орж байгаа чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлыг тооцсон болно. Хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тооцоо чиглэгдсэн болно.

Хоёр. Хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцсон байдал

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дараах 3 этгээдтэй холбогдон гарах зардлыг тооцлоо:

- 1/хуулийн этгээдийн зардал;
- 2/иргэнд үүсэх зардал;
- 3/төрийн байгууллагын зардал.

Хуулийн этгээдийн зардлыг тооцох ажлыг хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох, нэмэлт зардлыг тооцох гэсэн үе шаттайгаар зохион байгууллаа.

1/ Хуулийн этгээдийн зардал:

Дэлхийн хэмжээнд эрчим хүч, хөдөө аж ахуй, тээвэр, аж үйлдвэрийн салбар нүүрстөрөгч ялгаруулалтын хэмжээ өндөр байдаг бол Монгол Улсын хувьд нийт нүүрстөрөгч ялгарлын 93,2 хувийг эрчим хүч, хөдөө аж ахуйн салбар ялгаруулж байна. Эрчим хүчний салбарын хувьд эрчим хүч үйлдвэрлэлд ашиглаж буй хатуу түлшнээс үүдэлтэй ялгарал зонхилдог бол хөдөө аж ахуйн салбарын хувьд малын дотоод ферментац болон өтөг шивхээс ялгарч буй метан хий голлох эх үүсвэр болж байна.

Дэлхийн хэмжээнд авч үзвэл хүлэмжийн хийн ялгаралтын 35 хувийг эрчим хүчний, 17 хувийг тээврийн, 13 хувийг хөдөө аж ахуйн, 13 хувийг борлуулалтын салбар тус тус эзэлж байна (АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлагийн 2023 оны мэдээ).

Монгол Улсын хувьд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн гарах зардал өндөр байгаагаас эдийн засагт ихээхэн нөлөөлөл үзүүлж байна. Тухайлбал, агаарын дундаж температур урт хугацаанд 1°C-аар нэмэгдэх нь дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг 2 жилийн хугацаанд 0,5 хувиар бууруулж, сөрөг нөлөө үзүүлдэг болохыг харуулж байна.

Монгол Улсын эдийн засгийн бүтэц бүс нутгаас хамааран ялгаатай байдаг. Хангайн болон төвийн бүс нутаг хөдөө аж ахуйгаас ихээхэн хамааралтай байдаг бол говийн бүс нутаг нь уул уурхай давамгайлсан эдийн засагтай байдаг. Бүс нутгийн хувьд Хангайн бүс нутаг температурын хэлбэлзэлд онцгой мэдрэмтгий болохыг харуулж байна. Суурь тооцоогоор Хангайн бүс нутгийн дундаж температур 1°C-аар нэмэгдэх нь бүс нутгийн эдийн засгийн өсөлтийг 0,7%-иар

бууруулдагтай холбоотой юм¹. Температурын өөрчлөлт нь байгалийн гамшгийн давтамж нэмэгдэхэд хүргэдэг бөгөөд энэ нь эдийн засагт ч бас нөлөөлдөг.

Үндэсний Статистикийн Хорооны албан ёсны мэдээллээр, сүүлийн 10 жилд буюу 2016-2025 оны хооронд Монгол Улсад 26.5 сая толгой мал, жилд дунджаар 2.7 сая малын зүй бус хорогдол гарсан бөгөөд гамшгаас үүдэлтэй эдийн засгийн жилийн дундаж зардал 107.8 тэрбум төгрөг болжээ.

Монгол Улсын нүүрстөрөгчийн хийн ялгаруулалт 2019 онд түүхэн дээд хэмжээнд хүрч 88,7 сая тонн (Дэлхийн банк) CO₂ болон ДНБ-ий өсөлт ижил хандлагатай байна. CO₂ -ийн ялгаруулалт 2010 оноос өмнө ДНБ-ээс бага хурдтай өсөж байсан ч 2010 оноос хойш нүүрсний олборлолт, экспорт мэдэгдэхүйц нэмэгдсэн.

Жил ирэх тусам дулаан хангамжийн эрэлт нэмэгдсэнээс гадна дулаан хангамжтай холбоотой шууд зардал 2025 оноос хойш томоохон өөрчлөлтөд орж байна. Өмнө нь Улаанбаатар хотод 1м² талбайн халаалтын тариф 506 төгрөг, Дархан, Эрдэнэт, Чойбалсан зэрэг хотуудад 648 төгрөг байсан. Эдгээрийг Улаанбаатар хотод 936 төгрөг, бүс нутгийн хотуудад 1199 төгрөг болгон 85%-иар нэмэгдүүлсэн байна. Энэхүү тарифын шинэчлэл нь дулааны эрчим хүчний нийлүүлэлтийн зардал үйлдвэрлэлийн өртгөөс удаан хугацаанд доогуур байсан, улмаар эрчим хүчний салбарын санхүүгийн алдагдлыг нэмэгдүүлсэн нөхцөл байдлыг засах зорилготойгоор Засгийн газрын зохицуулалтын хүрээнд хийгдсэн. Энэхүү бодлогын шийдвэр нь эрчим хүчний салбарын үр ашгийг дээшлүүлэхэд зайлшгүй шаардлагатай боловч, нөгөө талаас Улаанбаатар хотын хамгийн эмзэг бүлгийн хүн амд санрүүгийн дарамт үүсгэх, улмаар уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлийг нэмэгдүүлэх хандлагатай байна.

Хүснэгт 1. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой зардал, Монгол Улс

Үзүүлэлт	Нэгж	Хамрах хугацаа	Жилийн дундаж
Малын хорогдол	сая толгой	2016-2025	2.7
Ой хээрийн түймэр	төө	2016-2025	145
Гамшгаас үүдсэн нас баралт	хүн	2000-2024	206
Гамшгаас үүдэлтэй дундаж хохирол	тэрбум төгрөг	2000-2024	75.3

Хүснэгт 1. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой зардал, Монгол Улс

Үзүүлэлт	Нэгж	Хамрах хугацаа	Жилийн дундаж
Малын хорогдол	сая толгой	2000-2025	2.2
Ой хээрийн түймэр	тоо	2000-2025	171
Гамшгаас үүдсэн нас баралт	хүн	2000-2025	210
Гамшгаас үүдэлтэй дундаж хохирол	тэрбум төгрөг	2000-2025	96.8

¹ Уур амьсгалын өөрчлөлтийн нийгэм, эдийн засагт үзүүлж болох нөлөө, учирч болох эрсдэл: Монгол Улсын жишээ, Ананд ба Хосбаяр, 2022 он

Монгол Улсад 2000-2025 онд гамшигт үзэгдлийн улмаас 5,453 хүний амь эрсдэж, 57.3 сая мал хорогдож, 2,516.2 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна. Тухайлбал, 2023–2024 оны зудын гамшгийн үеэр 9.4 сая мал хорогдож, олон мянган малчин өрхийн амьжиргаа, орлогын эх үүсвэр, амьдралын баталгаа алдагдсан. Энэ бол зөвхөн байгалийн гамшиг бус, уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн доройтол, нийгэм-эдийн засгийн эмзэг байдал давхцан илэрснийг анхааруулсан дохио байлаа.

Хуулийн төслийн ногоон санхүүжилт, карбон зах зээлтэй холбоотой бүлэгт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүлэмжийн хийг бууруулах үйл ажиллагаа хэрэгжүүлэхтэй холбоотой төсөл, арга хэмжээний хүрээнд иргэн, хуулийн этгээдэд ногоон санхүүгийн хэрэгсэл, хөшүүргийн хүрээнд төрөөс дэмжлэг үзүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг тооцуулж арилжаалах замаар нэмэлт орлого, хөрөнгө оруулалт татах боломж бүрдүүлж байна.

Төсөл, арга хэмжээний онцлогоос хамаарч үйл ажиллагаандаа олон улсын стандартын шаардлагыг хангахтай холбоотой тодорхой хэмжээний зардал гарах боловч тухайн хуулийн этгээдийн өрсөлдөх чадвар нэмэгдэх, нэмэлт санхүүжилт, орлого олох боломж бүрдэх тул хуулийн этгээдэд эерэг нөлөөтэй байна.

Түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах үйл ажиллагааны бодлого, зохицуулалт болон төрийн байгууллагын эрх, үүрэг тодорхой болж, мэдээллийн ил тод байдал хангагдах тул хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дэмжлэг болно.

Дүгнэлт: Хуулийн төслийг баталснаар хуулийн этгээдэд шууд нэмэлт зардал үүсэхгүй гэж үзэж байна. Харин эсрэгээрээ ногоон хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээлийн боломжит эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх замаар бизнесийн орчныг сайжруулах, эдийн засгийн илүү таатай нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой.

2/ Иргэнд үүсэх зардал:

Хуулийн төслийн хэрэгжилтийн хүрээнд иргэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үүргийг санхүүгийн хувьд хүлээхгүй, харин сайн дурын санаачилгыг хэрэгжүүлэх зорилгоор бусад этгээдийн хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд баталгаажсан, бүртгэгдсэн сааруулалтын үр дүнг зохих журмын дагуу өөрийн үүрэгт дүйцүүлэн тооцуулах боломжтой болно. Энэ нь иргэнд дүйцүүлэн тооцуулсан үүргийн хэмжээгээр санхүүгийн нэмэлт дэмжлэг авах боломж бүрдэнэ.

Хуулийн төслийн хүрээнд иргэн гэдэгт аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй хувь хүнийг багтаан үзсэн болно.

Дүгнэлт: Хуулийн төслийн хүрээнд иргэнд шинээр нэмэлт үүрэг, хариуцлага үүсгэхгүй тул иргэнд шууд санхүүгийн нэмэлт зардал бий болохгүй гэж үзэж байна.

3/ Төрийн байгууллагын зардал:

Хуулийн төслийн хэрэгжилтийг одоогийн институцийн тогтолцооны хүрээнд зохион байгуулах боломжтой гэж үзэж байна. Тухайлбал, төрийн байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгах, бүтэц зохион байгуулалтыг оновчтой тогтоох замаар уур амьсгалын өөрчлөлтийн асуудал хариуцсан бүтцийн нэгж, албан тушаалын орон тоог шинээр бий болгох тохиолдолд үүнтэй холбоотой зардал нэмэгдэхгүй тул батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

Улсын Их Хурлын тухайд:

- Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, зорилтот хөтөлбөрт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах асуудлыг тусган батлах;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон тухайн жилийн улсын төсөвт энэ хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг тусган батлах;
- Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх олон улсын үүргийн хүрээнд боловсруулсан тайлан, илтгэлийг хэлэлцэн сонсох бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлнэ.

УИХ-аас уур амьсгалын өөрчлөлтийн хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг батлах, хяналт тавих, хуулийн хэрэгжилтийн төсөв батлах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн, тайлан хэлэлцэж хяналт тавих бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд шинээр орон тоо нэмэх, бүтэц өөрчлөх шаардлагагүй тул төсөвт ямар нэгэн зардал нэмэгдэхгүй байна.

Засгийн газрын тухайд: Уур амьсгалын өөрчлөлтийн талаар Үндэсний тодорхойлсон хувь нэмэр, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөөг батлах, шинэчлэх, уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн салбар хоорондын уялдааг хангах, хуульд заасан асуудлаар хоёр болон олон талт олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцүүлэн карбон зах зээлийн бодлого, стратегийг батлах, ногоон санхүүжилтийн стратегийг батлах, улс, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх ногоон төсөл, хөтөлбөрийг тодорхойлсон ногоон таксономийг батлах, эрсдэлийн санд төвлөрүүлэх сааруулалтын үр дүнгийн хувь хэмжээг тогтоох, карбон зах зээлийн зохицуулалтын журмыг батлах, хүлэмжийн хийн ялгарлын хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын журмыг батлах, ногоон болон уур амьсгалын санхүүжилт, орлогын урсгалын бүртгэл, тайлагнал, ил тод байдлын журмыг батлах, Үндэсний платформын үйл ажиллагааны журмыг батлах, карбон бүртгэлийн журмыг батлах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Үүнээс харахад шинээр орон тоо нэмэх, бүтэц өөрчлөх шаардлагагүй тул төсөвт ямар нэгэн зардал нэмэгдэхгүй.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тухайд: Хуулийн төсөлд Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт, төлөвлөгөө, Үндэсний дасан зохицох төлөвлөгөөг боловсруулах, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцүүлэн карбон зах зээлийн үйл ажиллагааг удирдах, хоёр талт хэлэлцээрийн хамтарсан хороодын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах, Үндэсний эрх бүхий байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлж, холбогдох үйл ажиллагаанд зөвшөөрсөн тухай болон татгалзахгүй тухай тодорхойлолт олгох, оролцогч этгээдийг бүртгэх, хяналт тавих, бүртгэх, техникийн хороо, мэргэжлийн зөвлөлийг байгуулах, олон улсын гэрээгээр үүрэг хүлээсэн тайланг хянах, олон улсын байгууллагад хүргүүлэх, карбон зах зээлийн үйл ажиллагаанд хамаарах үйлчилгээний төлбөр, хураамж, шимтгэлийг тогтоох, Байгаль орчин, уур амьсгалын сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтыг хариуцан удирдаж, хяналт тавих, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийг тооцох, тайлагнах, баталгаажуулах журам батлах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх журмыг батлах, карбон зах зээлийн бодлого, стратегийг боловсруулах, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд салбар дундын бодлого, төлөвлөлтийн уялдааг хангах асуудлыг тодорхой болгосон.

Ийнхүү шинэ хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн орчин бүрдэх бөгөөд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийн хуваарилалтыг боловсронгуй болгох замаар дээрх чиг үүргийн хэрэгжилтийг хангах боломжтой тул улсын төсөвт нэмэлт зардал шаардлагагүй.

Хуулийн хэрэгжилтийн эхний арван жилийн хугацаанд олон улсын уур амьсгалын сан, хөгжлийн банкуудын буцалтгүй тусламж, техникийн туслалцаа, хөнгөлөлттэй зээл, хоёр талт хамтын ажиллагааны механизмын хүрээнд бүрдүүлэх ногоон хөрөнгө оруулалт, холимог санхүүжилтийн эх үүсвэр, зорилтот бонд, дотоод гадаадын хуулийн этгээд болон хувь хүний санхүүжилтээс бий болох нэмэлт эх үүсвэрээр хуулийн хэрэгжилтийг хангах бүрэн боломжтой.

Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тухайд: Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт болон Үндэсний дасан зохицох төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээний эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт татах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ногоон санхүүжилтийн стратегийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;

- ногоон хөгжил болон урт хугацааны хүлэмжийн хийн ялгарал багатай эдийн засгийн шилжилтийг санхүүжүүлэх бодлого, арга хэмжээг тодорхойлох;
- ногоон таксономийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны саналыг үндэслэн холбогдох байгууллагатай хамтран боловсруулах;
- Үндэсний тодорхойлсон хувь нэмэр, Үндэсний дасан зохицох төлөвлөгөө болон урт хугацааны хүлэмжийн хийн ялгарал багатай хөгжлийн бодлогыг Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгах, хэрэгжилтэд хяналт тавих.

Дээрх бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд одоогийн бүтэц, зохион байгуулалтын хүрээнд ажиллах боломжтой бөгөөд улсын төсөвт нэмэлт зардал шаардахгүй.

Салбарын болон бусад төрийн захиргааны төв байгууллагын тухайд: салбарын хэмжээнд хүлэмжийн хийн тооллоготой холбоотой мэдээллийг цуглуулах, мэдээллийн санд оруулах, тайлагнах, баталгаажуулах, арга хэмжээг салбарын хэмжээнд тодорхойлж, улсын төсөвт тусгуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах, салбарын хүлэмжийн хийн ялгарлыг тооцох аргачлалыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах, хүлэмжийн хийн ялгарлыг тооцох, салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, салбарын хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх, хүлэмжийн хийн ялгарлын тооллоготой холбоотой өгөгдөл мэдээлэл цуглуулах, тайлагнах үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэх бүрэн эрхтэй байх ба тэдгээрийг төсөвт нэмэлт зардал үүсгэхгүйгээр хэрэгжүүлэх боломжтой байна.

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын тухайд: Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн аймаг, нийслэлийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлан орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавих, Засаг дарга тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээг хийлгэх, тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд төлөвлөгөөг боловсруулж, орон нутгийн төсөвт тусгуулах хэрэгжилтийг ханган тайлагнах эрх, үүргийг тодорхойлж өгсөн тул нэмэлт зардал гарахгүй.

Үндэсний зохицуулагч байгууллагын тухайд: Хүлэмжийн хийн үндэсний тооллого, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтыг удирдан зохион байгуулах, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр, Үндэсний дасан зохицох төлөвлөгөөний хэрэгжилтийн гүйцэтгэлийн жилийн тайланг боловсруулж, дээд шатны байгууллагад хүргүүлэх, карбон зах зээлийн хүрээнд үүсэх карбон кредитийн болон олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүнгийн бүртгэлийн системийг удирдах, карбон зах зээлийн төсөл, хөтөлбөрийн санал, баримт бичгийг хянах, шаардлага хангасан төслийг бүртгэх, сааруулалтын үр дүнгийн бүртгэл, шилжүүлгийг хянах, давхар тооллогоос сэргийлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, Парисын хэлэлцээрийн шаардлагад нийцүүлэн хүлэмжийн хийн ялгарлын тэнцэлд харгалзах тохируулгыг хийх, Уур амьсгалын

үндэсний платформын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах, уур амьсгалын болон ногоон санхүүжилтийн эх үүсвэр, зориулалт, хэрэгжилт, үр дүнгийн мэдээллийг бүртгэх, хянах, тайлагнах, эрсдэлийн сангийн бүртгэл, удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх гэсэн үндсэн чиг үүргийг гүйцэтгэнэ.

Энэхүү үүргийг шинээр байгууллага, бүтэц бий болгохгүйгээр биелүүлж, гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх чиглэлээр ажиллах ёстой. БОУАӨЯ-ны чиг үүргийн хүрээний Засгийн газрын агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газрын одоогийн бүтэц, зохион байгуулалт, орон тоонд нэмэлт оруулахгүйгээр дээрх эрх, үүргийг хэрэгжүүлэх чиглэл баримтлах бөгөөд тухайн агентлагийн эрх хэмжээг нэмэгдүүлэх боломжийг цаашид судлах нь зүйтэй байна. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр олон улсын болон дотоодын санхүүжилтийн боломжит олон талт эх үүсвэрийг оновчтой зохион байгуулан хэрэгжүүлснээр Байгаль орчин, уур амьсгалын сангийн орлогыг нэмэгдүүлж, хуулийн төслийн хэрэгжилтийг бүрэн хангах боломж бүрдэнэ.

Бусад байгууллага, хороо, комиссын тухайд: Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой салбар дундын асуудлаар Засгийн газрын түвшинд тодорхой асуудлаар ажлын хэсэг байгуулах замаар шийдвэрлэх боломжтой.

Дүгнэлт: Хуулийн төслийн хүрээнд төрийн байгууллагуудын хувьд шинээр орон тоо нэмэгдэх боломжтой боловч тухайн байгууллагуудын дотоод бүтэц, зохион байгуулалт, ажил үүргийн хуваарийг оновчтойгоор өөрчлөх замаар хэрэгжилтийг хангах боломжтой. Иймд улсын төсөвт нэмэлт зардал үүсэхгүй бөгөөд шаардлагатай санхүүжилтийг гадаад хамтын ажиллагаа, олон улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэх боломж бүрдэнэ.

Гурав. Нэгдсэн дүгнэлт

Дэлхийн болон улс орны эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан одоогийн батлагдсан орон тоо, улсын болон орон нутгийн төсөвт нэмэлт дарамт болгохгүйгээр зардлын тооцоог шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна. Зардлын тооцооны нэгдсэн судалгааны үр дүнгээс үзэхэд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад нэмэлт санхүүгийн дарамт үүсэхгүй, төсөвт дарамт учруулахгүй байх боломжтой нь харагдаж байна.

Хуульд заасан хүлэмжийн хийн үндэсний тооллого, бүртгэл, уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, тайланг боловсруулах, олон улсын байгууллагад илгээх үйл ажиллагааг батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд тухай бүрт нь шийдвэрлэх боломжтой байна.

Харин уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүлэмжийн хийг бууруулахад чиглэсэн төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж буй хуулийн этгээд, иргэнд нэмэлт санхүүгийн эх үүсвэр татах боломж нэмэгдэж, инноваци, дэвшилтэт технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх давуу тал үүснэ.

Үндэсний платформ бүрдүүлэх, мэдээллийн сан байгуулах ажлыг олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хүрээний санхүүжилт, хандив, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх, түүнчлэн төрийн үйлчилгээнд

шаардлагатай техникийн болон санхүүгийн дэмжлэгийг татах замаар шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

Түүнчлэн нүүрстөрөгчийн зах зээлтэй уялдсан механизм, дотоодын төсвийн эх үүсвэрүүд, олон улсын тусламж, хандив, олон нийтийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, дэмжих замаар санхүүжилт, зардлыг шийдвэрлэх боломжтой.

Төсөлд тусгагдсан “карбон зах зээлийн үйл ажиллагаанд хамаарах үйлчилгээний төлбөр, хураамж, шимтгэл”-ийн орлогоос хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тодорхой хэсгийг санхүүжүүлэх боломж нь хууль хэрэгжилтийн явцад бүрдэхээр байна.

--oOo--